

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

**ДОТООД АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС, ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

ДОТООД АУДИТЫН НЭГЖ: ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН –

АБ4000

ДОТООД АУДИТЫН НЭР: ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ДОТООД АУДИТ

**ДОТООД АУДИТАД ХАМРАГДАХ ХУГАЦАА: 2024 ОН, 2025 ОНЫ 1-2 ДУГААР
УЛИРАЛ**

2025 он

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: ЦУОШГ-ЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС, ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

АУДИТЫН ТӨРӨЛ: ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ДОТООД АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА: 2025.07.03-04

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ДАРГА: ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.ОЮУНБИЛЭГ

АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮН:

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.НАРАНЧИМЭГ, Э.ЦЭЦЭГЖАРГАЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУ	Монгол Улс
ЗГ	Засгийн газар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
УЦУОШТ	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
ҮАГ	Үндэсний аудитын газар
ДАХ	Дотоод аудитын хороо
ХШДАХ	Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтэс
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

1.1. Дотоод аудитын танилцуулга:

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны "Нийтлэг журам батлах тухай" 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм" холбогдох бусад хууль тогтоомж, журмыг тус тус үндэслэн Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны "Дотоод аудит, хяналт шалгалт хийх ажлын удирдамж"-ийн дагуу төлөвлөгөөт бус захиргаа, санхүүгийн дотоод аудит, технологийн хяналт шалгалтыг хийлээ.

Дотоод аудитыг Хяналт, шинжилгээ дотоод аудитын хэлтсийн дарга Х.Оюунбилэг ахлаж, ахлах мэргэжилтэн С.Наранчимэг, ахлах мэргэжилтэн Э.Цэцэгжаргал нар 2025 оны 07 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Дотоод аудитаар тус төвийн 2024 оноос 2025 оны эхний хагас жилийн байдлаарх захиргаа, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод аудит хийж төвийн даргын А, Б тушаал, боловсон хүчний баримт бичиг, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, зарцуулалт үр дүн, орлого зарлага болон ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, бусад холбогдох зааврын мөрдөлт зэрэгт хяналт шалгалт илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, цаашид дахин давтахгүй байх талаар санал, дүгнэлт боловсрууллаа.

1.1. Байгууллагын танилцуулга

Сэлэнгэ аймгийн анхны цаг уурын станцыг 1939 оны 12 дугаар сарын 01-нд Баянгол суманд байгуулан байнгын үйл ажиллагаатай, нэгдсэн шинжилгээний ажлын хөтөлбөрөөр ажиллуулж эхэлсэн байна. Ингэж албан ёсоор ажиллаж эхэлсэнээр Сэлэнгэ аймагт Ус цаг уурын байгууллагын эх үүсвэр тавигдсан ажээ. Станцын даргаар орос мэргэжилтэн ажиллаж Монгол ажиглагч нар дагалдан суралцаж байсан. Баянгол суманд байгуулсан станц нь анхандаа 3-4 хугацааны ажиглалт хийдэг байснаа 1941 онд шаао хөөргөлтийн ажиглалт нэмэгджээ. 1942 оны 09 дүгээр сарын 17-нд Сүхбаатар хотын орчим Орхон гол дээр, 10 дугаар сарын 10-нд Баянгол суманд Хараа нол дээр ус зүйн анхны харуулууд байгуулжээ. 1954 онд Ус ба цаг агаарын шинжилгээний хорооны бүтцэд урьдчилан мэдээлэх товчоо анх буй болжээ. Анхны хөдөө аж ахуйн цаг уурын харуулыг 1959 оны 08 дугаар сарын 09-нд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Зэлтэр суманд, Мандал сум буюу Зүүнхараа хотод анхны ХАА цаг уурын станцыг 1964 оны 09дүгээр сарын 01-нд байгуулжээ.

УЦУАУЕГ-ын даргын 1964 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 12 тоот тушаалаар "Сэлэнгэ аймгийн Цаг уурын товчоо"-г байгуулсан байна. Энэ нь аймгийн хэмжээний бүх сумдад ажиллаж байсан цаг уурын станц, салбаруудын ажлыг шалган зааюарлах, шинжилгээний тайлан материалд анхны дүгнэлт хийх, орон нутгийг ус цаг уурын батттай мэдээний эх сурвалжаар хангах, бусад сумдад шинэ салбарыг зохион байгуулж, цаг уурын станцуудыг материаллаг бааз, багаж

иөхөөрөмжөөр хангах, аж ахуй санхүүг зохион байгуулалтаар шууд удирдан ажиллах зорилготой байв.

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2023 оны А/83 тоот тушаалаар Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-ийг 3 хэлтэс, мэргэжлийн 8 салбар, сум орон нутагт анхан шатны 24 ажиглалтын нэгж салбартай 80 алба хаагчтай байхаар баталсан. Одоо Захиргаа санхүү, аж ахуйн хэлтэс, Цаг уур, орчны технологийн хэлтэс, Мэдээлэл үйлчилгээний хэлтэс гэсэн 3 хэлтэстэй, цаг уурын 7 өртөө, 6 харуул, ус судлалын 10 харуул, агаарын чанарын 2 харуул, цаг агаарт зориудаар нөлөөлөл 3 экспедицтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Хөрөнгө, мөнгө захиран зарцуулалтын байдлыг авч үзэхэд:

Төрийн сангийн дансны дугаар	100130013015
Төрийн сангийн нэмэлт дансны дугаар	100130013404
1 дүгээр гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан, нэр, хугацаа	О.Ганбат 2023.08.01-2025.06.30
2 дугаар гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан, нэр, хугацаа	Б.Гантуяа 2017.01.02-2025.06.30

Тушаал, шийдвэрийн талаар:

Сэлэнгэ аймгийн УЦУОШТ нь 2024 онд үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 94, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 56, 2025 оны эхний хагас жилийн байдлаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 35, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 39-ыг тус тус баталсан байна.

Санхүү, төсөв, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын талаар:

Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-ийн 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгө 156,562.1 мянган төгрөгийн, эргэлтийн бус хөрөнгө 1,205,334.7 мянган төгрөгийн, нийт 1,361,896.9 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

Санхүүгийн байдлын тайлан

мянган төгрөгөөр

№	Үзүүлэлтүүд	2024.12.31	2025.06.30	Өөрчлөлт
1	Төрийн сангийн харилцах	0.0	25,310.1	25,310.1
2	Авлага	0,0	0.0	(0,0)
3	Бараа материал	126,491.3	131,251.9	4,760.6
Эргэлтийн хөрөнгийн дүн		126,491.3	156,562.1	10,712.0
4	Үндсэн хөрөнгө	1,169,875.9	1,205,334.7	35,458.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,169,875.9	1,205,334.7	35,458.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1,296,367.3	1,361,896.9	65,529.6
5	Өр төлбөр	0,0	16,691.7	16,691.7
6	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,296,367.3	1,345,205.1	48,837.8
ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		1,296,367.3	1,361,896.9	65,529.6

Төсвийн орлогын талаар:

Сэлэнгэ аймгийн УЦУОШТ нь 2024 онд улсын төсвөөс 3,128,130,0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 3,128,130,0 мянган төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлого 1000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 1000,0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн гэж тайлагнасан байна.

Орлогын дэлгэрэнгүй мэдээлэл

мянган төгрөгөөр

№	Орлогын нэр	2024 оны 4 дугаар улирал	
		Төлөв	Гүйц
1	Үндсэн данс	3,128,130.0	3,128,130.0
2	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,000.0	1,000.0
3	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,000.0	98,249.5

Төсвийн зарлагын талаар:

Тус байгууллага нь 2025 оны 2 дугаар улирлын байдлаар урсгал зардалд 1,637,593,8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,634,391,2 мянган төгрөгийг захиран зарцуулсан гэж тайлагнасан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөгөөр

Нэр	2025 оны 2 дугаар улирал		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Зардлын дүн	1,637,593.8	1,634,391.2	3,202.5
Цалин хөлс, нэмэгдэл урамшил	1,366,222.2	1,65,312.3	909.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,925.2	166,991.0	1,934.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,914.5	42,914.5	0.0
Хангамж бараа материалын зардал	8,224.8	8,116.5	108.2
Нормативт зардал	2,260.0	2,260.0	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	42,739.8	42,739.8	0.0
Томилолт, зочны зардал	2,135.8	2,135.8	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,211.5	2,961.1	250.3
Бараа үйлчилгээний бусад зардал	960.0	960.0	0.0
Урсгал шилжүүлэг	0.0	0.0	0.0

Худалдан авах ажиллагааны талаар:

Сэлэнгэ аймгийн УЦУОШТ нь 2024 онд УЦУОШТөвийн өргөтгөлийн дээврийн их засварын ажлыг Аймгийн худалдан авах ажиллагааны газраас харицуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт:

Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-ийн шилэн дансны мэдээлэл байршуулалт сайн байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Дотоод аудитын зорилго

Тус төвийн захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж зөвлөмж өгөх, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, шинжилгээний ажлын заавар, ажиглалт хэмжлийн технологийн мөрдөлтөд хяналт, шалгалт хийх, үл тохирлыг илрүүлэх, арилгах арга замыг зааж мэргэжлийн зөвлөгөө өгөх, удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.

2.2. Дотоод аудитын хамрах хүрээ

Энэхүү дотоод аудитыг дараах асуудлын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 2.2.1. Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдал, хэрэгжилт;
- 2.2.2. Батлагдсан төсөв, түүний хэрэгжилт;
- 2.2.3. Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, анхан шатны баримтын бүрдэл, ашиглалт, зарцуулалтын байдал;
- 2.2.4. Төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал;
- 2.2.5. Албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, олголт, баримтын бүрдэлт, тооцоо бодолт;
- 2.2.6. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, хөтөлбөрийн биелэлт, шинжилгээний ажлын заавар, ажиглалт хэмжлийн технологи мөрдөж байгаа байдал, хэрэгжилт;
- 2.2.7. Бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэр.

Дотоод аудитад хамрагдаагүй хэсэг:

Төрийн аудитын газрын санхүүгийн аудитын тайланд дурдсан асуудлыг хамруулаагүй болно.

2.4. Дотоод аудитын аргачлал

Аудитыг гүйцэтгэхэд ДАМПОУС болон АДБОУС 100-400, 4000 дугаар стандарт, байгууллагын анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, тодруулга авах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, хөтөлбөр, горимын дагуу нотлох баримт цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үр нөлөөтэй байдлыг үнэлэхдээ байгууллагын удирдлагатай утсаар холбогдон, асуулга авах, холбогдох баримт материалыг түүвэрлэн үзэх зэрэг горимуудыг хэрэгжүүллээ.

Хүний нөөцийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо, удирдлагын шийдвэр гаргалт, эрсдэлийн үнэлгээ, ёс зүй, хариуцлагын тогтолцоо, санхүүгийн үйл ажиллагааны журмууд болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэж үр нөлөөтэй байдлын үнэлгээг хийлээ.

3.1 Байгууллагын засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үр нөлөөтэй байдлын үнэлгээний талаар:

Шалгуур

- Байгууллагын даргын дэргэдэх зөвлөл
- Дотоод хяналтын тогтолцоо
- Менежментийн төлөвлөлт ба эрсдэлийн удирдлагын тогтолцоо
- Хүний нөөцийн бодлого
- Хариуцлагын тогтолцоо
- Ёс зүй, үнэт зүйлсийн тодорхойлолт

- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нийтлэг журам”

Бодит нөхцөл байдал

Байгууллагын засаглалын төлөвшил нь дараах байдлаар үнэлэгдэж байна.

Байгууллагын засаглалын төлөвшил нь дараах байдлаар үнэлэгдэж байна.

Шалгуур	Үнэлгээний түвшин
Удирдлагын зөвлөл	<u>2-р түвшин буюу Давтамжтай.</u> - Сэлэнгэ аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Даргын дэргэдэх зөвлөл байгуулах, журам батлах тухай” А/13 дугаар тушаалаар төвийн өмнө тулгарч байгаа зорилт, санхүү аж ахуй, ажиглалт-шинжилгээний ажлын үр дүн, зохион байгуулалтын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх байх зорилгоор захирлын дэргэдэх зөвлөх эрхтэй зөвлөлийг байгуулсан байна. - Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” А/19 дүгээр тушаалаар гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, хүүхдийг сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг дэмжих зорилгоор байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг байгуулсан ба тус зөвлөл нь 2024-2025 онд тодорхой үйл ажиллагаа явуулж эхэлсэн. - Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-ийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” А/01 дугаар тушаалаар байгууллагын үндсэн ба эргэлтийн хөрөнгө, цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний багаж тоног төхөөрөмжид үзлэг хийх, эвдрэлийн акт тогтоох, чанар байдал, үнэлгээ хийх, хөрөнгийг бүртгэж авах өмч хамгаалах үүрэг бүхий байнгын зөвлөлийг шинэчлэн байгуулсан байна. - Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 06 дүгээр сарын 02-ны өдрийн “Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, журам шинэчлэн батлах тухай” А/31 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа баримт бичигт хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, хөтлөгдөж дууссан хэргийг архивт шилжүүлэхэд бэлтгэх явцад баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, Төрийн архивт баримт шилжүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор байгууллагын дэргэд баримт бичиг шалгах комиссыг байгуулсан байна.
Дотоод хяналтын тогтолцоо	<u>1-р түвшин буюу Эхлэлийн.</u> Сэлэнгэ аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “ УЦУОШТ-ийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” А/03 дугаар тушаалаар байгууллагын дотоод хяналтын нэгжийн мөрдөх журмыг баталсан байна.
Хүний нөөцийн тогтолцоо	<u>3-р түвшин буюу Томьёолсон.</u> Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журамд үндэслэн хүний нөөцийн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилладаг.
Хариуцлагын тогтолцоо	- 2024 онд Сэлэнгэ аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг баталсан байна. - Сонгон шалгаруулалт явуулах, түүнд тавигдах шаардлага болон хариуцлагын тогтолцоо, сахилгын арга хэмжээ авах, шийтгэл ногдуулах

	зэрэг арга хэмжээ авахдаа хуульд нийцүүлэн, хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудад тусган хэрэгжүүлж ажиллаж байна.
Ёс зүй, үнэт зүйлсийн тогтолцоо	<u>3-р түвшин буюу Томьёолсон.</u> - Сэлэнгэ аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн "А/04 дүгээр тушаалаар байгууллагын Ёс зүйн хороог шинэчлэн батласан байна. Засгийн газрын 2023 онд батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.
Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай эсэх	<u>1-р түвшин буюу Эхлэлийн.</u> Байгууллагын хэмжээнд мөрддөг эрсдэлийн удирдлагын бодлого, журам байхгүй.
Эрсдэлээ тодорхойлдог эсэх	<u>1-р түвшин буюу Эхлэлийн.</u> Байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тооцдоггүй.
Эрсдэлийн үнэлгээ хийдэг эсэх	<u>1-р түвшин буюу Эхлэлийн.</u> Эрсдэлийн үнэлгээ хийдэггүй.
Эрсдэлийн талаар нэгдсэн ойлголт, чиг хандлагатай эсэх	<u>2-р түвшин буюу Давтамжтай.</u> Эрсдэлийн талаарх ойлголт зөвхөн удирдлагын түвшинд тогтсон.
Ажилтан бүр дотоод хяналтын үүрэг хариуцлага хүлээдэг байх	<u>1-р түвшин буюу Эхлэлийн.</u> Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч албан хаагчдын ажлын чиг үүрэгт дотоод хяналтын үүрэг тодорхой түвшинд тусгагдаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч албан хаагчдад дотоод хяналтын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байна.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛУУД

Илэрсэн асуудал 1	Шинжилгээний ажиглалтыг хийхдээ "Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар /ШЗ.И.01.03.2014/ буюу цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар /XIV дэвтэр/" зааврыг бүрэн баримтлаагүй.
Бодит нөхцөл байдал:	
1. Ажиглалтын хугацааны болон завсрын хугацааны цаг агаарын үзэгдлийг тасралтгүй ажиглан ЦД-1 дэвтэрт тэмдэглэх, шөнийн хугацаанд ажиглагдаж буй үзэгдлийн эрч хүчийг зөв тодорхойлох; 2. Автомат станцын хөрсний мэдрүүр зөв байрлуулах, жаазны доторх хөрсийг нарийн шигшүүрээр шигшиж, үзэгдэл ажиглагдах бүрд байрлалыг шалгаж тохируулах, талбайн зам болон хашааг байнгын тордож байх; 3. Ажиглалтын талбайн ургамал хэт өндөр ургасан, талбайн өвс 20см-ээс ихгүй байх ёстой, талбайн зам, тохижилтыг сайжруулах; 4. Нэгж салбарын өдөр тутмын ажиглалт тасралтгүй хэвийн ажиллаж чадахгүй зарим үед доголдол үүсдэг байна. Энэ нь ажиглагчийн ур чадвар ажлын хариуцлага, багаж төхөөрөмжийн гэмтэл зэргээс шалтгаалсан; 5. Үзэгдэлгүй үед үүлний хэмжээгээр өнгөрсөн болон ажиглалтыг хугацааны цаг агаарын байдлыг тодорхойлоход зөрүүтэй; 6. Агаар, хөрсний үнэмлэхүй их, бага утга зөрөх, нойтон цас ажигласан боловч аюул агаар мэдээ зохиогоогүй, нар, сарны эрчимшил, хүрээ ажиглах, үүлний шифр болон 7 дугаар бүлэг буруу кодлох, шат дараалсан техник, шүүмж шалгалтыг чанартай хийгээгүй.	
Шалгуур үзүүлэлт:	
Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2014 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/57 тоот тушаалаар баталсан "Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар /ШЗ.И.01.03.2014/ буюу цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар /XIV дэвтэр/" заавар.	
Үзүүлэх нөлөө /үр дагавар/:	
Шинжилгээний ажиглалтын технологи мөрдөж ажилаагүйгээс болж олон жилийн цувааны үнэн бодит байдал алдагдах	

Зөвлөмж:

1. Улирлын онцлог байдал тэдгээрт харгалзах үүл үзэгдэл түүний уялдаа холбоо, ямар үзэгдэл ямар утгат хүрэхэд аюул агаар мэдээ зохиох, үүл үүсэх, хөгжих, хувьсах, сарних нөхцөл, хамт ажиглагдах үүл болон техник, шүүмж шалгалтаар илэрсэн алдааг засах сургалтыг тогтмол хийх;
2. Зарим сургалтыг техникч нар харилцан бие биедээ хичээл орж өөрсдийн чадварыг дээшлүүлэх, үүнийг төвөөс зохион байгуулах;
3. Цаг уурын өртөө, харуулын техникч нар цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар /"ШЗ. II.12.01.2014"/-ыг баримтлах, нэн тэргүүнд цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн талаар 7-19 дугаар хуудсыг бүрэн өөрийн болгох, шат дараалсан техник шалгалтыг тогтмол хийж хэвших;
4. Хөтөлбөрт ажлаас гадна төвийн инженер техникчид орон нутгийн уур амьсгал судалгаанд хэрэгтэй гэж олон төрлийн мэдээ мэдээллийг түүвэрлэн хийдэг. Энэ судалгааны ажил нь давхцал ихтэй байгаа эсэх талаар дахин судалж төвийн удирдлага, зөвлөлөөр ярилцаж шийдэх шаардлагатай;
5. Цаашид ажиглалт, хэмжлийн технологийн мөрдөлтөд хяналт тавих, алдаа, зөрчил, үл тохирлыг арилгах, салбар хариуцсан ахлах техникч, технологич инженер нар техник, шүүмж шалгалтын чанар, үр дүн /үл тохирол арилсан эсэх/-г хэлтсийн хурлаар хэлэлцэж, хариу зааварчилгааг нэгдсэн байдлаар гаргаж, үл тохирол бүрийг арилгах;
6. Албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, мэргэшил, ур чадварыг үнэлэх, мэргэшүүлэх хичээл сургалт тогтмол хийх, удирдлагын зүгээс туслан дэмжих, хэт журамлан ёс зүйгүй хандлага бий болох нөхцөлөөс сэргийлэх нь зүйтэй.

Илэрсэн асуудал 2

Ажиглалтын багаж тоног төхөөрөмж дутагдалтай.

Бодит нөхцөл байдал:

1. Хүдэр харуулд цасны жин дутагдалтай, Баруунхараа, Орхон өртөөдийн зарим гүний термометр дутагдалтай, Баруунбүрэн харуулын чийгийн мэдрүүр гэмтсэн, Зүүнбүрэн автомат ажиллахгүй доголдоод, сүлжээ болохгүй, Цагааннуур тог баригчгүй, Зүүнхараа ажиглалтын талбай замаар яваагүй, Хүдэр, Бугант талбайн өвс ихтэй, Хүдэр, Хушаат харуулд өвөл чийг зөрөөтэй, Сүхбаатар, Орхон, Зүүнхараа ажиглагч дутуу, Баруунбүрэн мэдрүүрийн утас тасарсан, өөр мэдрүүр тавьсан буруу заагаад одоо механик багаж ажиллаж байна.
2. Бэлчээрийн төлөв байдлын ажиглалт хийхэд хэрэглэдэг 50м-ийн урттай шугам, зургийн аппарат, хатаах шүүгээ шаардлагатай.
3. Комбинеzon нь ус шүүрч нэвчдэг үүнийг өмсөөд голд удаан зогсохоор хамгаалалт болж чадахгүй, ул нь халтирч унах аюултай, усны гутал шаардлага хангахгүй нөхөөс авдаггүй зэрэг бэрхшээл байна.
4. ХААЦУ-ын ажиглалтыг таримал болон бэлчээрийн ургамал, хөрсний чийг, талхагдлын ажиглалтыг хийдэг. Ургамлын үе шатны ажиглалтыг төлөөлөх ургамлуудад хийн талбайд пайз зүүж өнгөөр ялгасан байна. ХААЦУ-ын инженерийн ажлын баримт бичгийн эмх цэгц сайн, өөрийгөө хөгжүүлэх, ур чадвараа нэмэгдүүлж ажилласан байна.

Шалгуур үзүүлэлт:

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2014 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/57 тоот тушаалаар баталсан "Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар /ШЗ.II.01.03.2014/ буюу цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар /XIV дэвтэр/" заавар.

Үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Шинжилгээний ажиглалтын багаж тоног төхөөрөмж дугдалтай байх нь хөтөлбөр тасалдах эрсдэлтэй

Зөвлөмж: Бүх төрлийн багажийн баталгаажуулалтыг цаг тухайд нь хийлгэж хэвших хэрэгтэй. Цаг уурын автомат станцын газардуулгыг сайн хийх, одоогоор 2 өртөөнд газардуулгыг хийсэн /8-10 Ом/. Хэмжих хэрэгсэл дутуу, эвдрэл, гэмтэлтэй байх нь хөтөлбөрт тасрах, ажиглалт хэмжлийн үр дүнд үл тохирол, алдаа, зөрчил гарах эрсдэлтэй тул үүнээс сэрэмжлэн жил бүрийн захиалгад хэмжих хэрэгсэл, сэлбэг эд ангийг оруулж хангалт хийх, хэмжих хэрэгслийг гамтай, үзлэг үйлчилгээ, засвар хийж ашиглаж хэвших, шалгаж баталгаажуулахдаа бүх мэдрүүр, эд ангийг

шалгаж бүрэн баталгаажуулах, шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний хөтөлбөрийг заавал бүрэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах шаардлагатай.

Ус судлалын 10 харуултай тэдгээрийн шинжилгээний ажиглалтын хөтөлбөрт ажил хэвийн явагдаж байна. Харуулуудад байнгын хяналт шалгалт тавьж ажилладаг. Усны харуулын ажиглалт амь дүйсэн ажил байдаг. Хамгийн эхний ээлжид хувцас хэрэглэлийн чанар сайн байх.

Хэмжих хэрэгсэл дутуу, эвдрэл, гэмтэлтэй байх нь хөтөлбөрт тасрах, ажиглалт хэмжлийн үр дүнд үл тохирол, алдаа, зөрчил гарах эрсдэл гарах тул үүнээс сэрэмжлэн жил бүрийн захиалгад хэмжих хэрэгсэл, сэлбэг эд ангийг оруулж хангалт хийх, хэмжих хэрэгслийг гамтай, үзлэг үйлчилгээ, засвар хийж ашиглаж хэвших, шалгаж баталгаажуулахдаа бүх мэдрүүр, эд ангийг шалгаж бүрэн баталгаажуулах, шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний хөтөлбөрийг заавал бүрэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах шаардлагатай

Илэрсэн асуудал 3	Баримтын нэгдсэн тооллого хийгээгүй, задгай баримтыг бүртгэн хаяг заагуур хийж тавиурт байршуулах, данс бүртгэл хангалтгүй.
Бодит нөхцөл байдал: Архив мэдээллийн сан хариуцсан ажилтан эзгүй байсан. Архивын өрөөнд задгай баримт их байна. Шинжилгээний баримт, удирдлагын баримт бичиг буюу байгууллагын архив нэг өрөөнд хаяг заагуур хийгдээгүй байна. Архивын өрөө нь стандарт шаардлага хангаагүй, чийг, температурын хэмжилт хийгдээгүй, тэмдэглэл байхгүй, хадгаламжийн нэгжийн байршлын заагуур буруу байна.	
Шалгуур үзүүлэлт: Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмыг зэргийг баримтлан ажиллах үүрэгтэй.	
Үзүүлэх нөлөө /үр дагавар/: Архивын баримт эмх цэгцгүй, тохиромжгүй нөхцөлд байсанаар баримтын хадгалалт хамгаалалт муудаж, үргэдэж алга болох магадлал өндөр байна.	
Зөвлөмж: Шинжилгээний баримт хариуцсан ажилладаг архив мэдээллийн сан хариуцсан ажилтан байхгүй байсан архивын өрөөний эмх цэгц сайн байх ёстой. Архивын өрөөнд задгай баримт их байна. Иймээс шинжилгээний баримт бичиг архивын цаасан болон цахим баримтын нэгдсэн тооллогыг салбар бүрээс алба хаагч оролцуулан тушаал гаргаж хийх шаардлагатай. Тооллогоор баримт бүрийг баримтын бүртгэлтэй тулган шалгаж тооллогын акт, бусад баримт бичгийг бүрдүүлэн ажиллах шаардлагатай. Архивын өрөө нь стандарт шаардлага хангаагүй, чийг, температурын хэмжилт хийгдээгүй, тэмдэглэл байхгүй, хадгаламжийн нэгжийн байршлын заагуур буруу байна.	

Илэрсэн асуудал 4	Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсч байж хөдөлмөрийн гэрээг байгуулах тухай заалтыг зөрчиж, шууд хөдөлмөрийн гэрээг албан хаагчтай байгуулсан.
Бодит нөхцөл байдал: Хөдөлмөрийн гэрээг урьдчилан байгуулж томилсон 18 албан хаагч байна. 1. 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн Т.Сүнжидмааг ажилд томилох тухай Б/13 дугаар тушаал; 2. 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Х.Саруулыг ажилд томилох тухай Б/16 дугаар тушаал; 3. 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Г.Намжилмааг ажилд томилох тухай Б/26 дугаар тушаал; 4. 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Б.Амаржаргалыг ажилд томилох тухай Б/27 дугаар тушаал; 5. 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Х.Амаржаргалыг ажилд томилох тухай Б/32 дугаар тушаал; 6. 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Э.Содхүүг ажилд томилох тухай Б/34 дүгээр тушаал; 7. 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Г.Эрхэмбаатарыг ажилд томилох тухай Б/35 дугаар тушаал; 8. 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн Д.Байгалмааг ажилд томилох тухай Б/41 дүгээр тушаал;	

9. 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн Г.Ган-Эрдэнийг ажилд томилох тухай Б/42 дугаар тушаал;
10. 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн Ш.Чулуунцэцэгийг ажилд томилох тухай Б/43 дугаар тушаал;
11. 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Б.Долгоржавыг ажилд томилох тухай Б/49 дүгээр тушаал;
12. 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн М.Энхцэцэгийг ажилд томилох тухай Б/50 дугаар тушаал;
13. 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Л.Анхбаярыг ажилд томилох тухай Б/51 дүгээр тушаал;
14. 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн С.Энхсэлэнгийг ажилд томилох тухай Б/14 дүгээр тушаал;
15. 2025 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Т.Гэндэнжамцийг ажилд томилох тухай Б/19 дүгээр тушаал;
16. 2025 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн И.Оюунцэцэгийг ажилд томилох тухай Б/20 дугаар тушаал;
17. 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Т.Сүнжидмааг ажилд томилох тухай Б/26 дугаар тушаал;
18. 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Хишигдэлгэрийн Саруулыг ажилд томилох тухай Б/38 дугаар тушаал.

Шалгуур үзүүлэлт:

Хөдөлмөрийн хуулийн 4.1.9."хөдөлмөрийн гэрээ" гэж хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсоны дагуу хийсэн тохиролцоог;

Үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Хөдөлмөрийн маргаан үүсэх

Зөвлөмж:

Тухайн албан тушаалын албан тушаалын тодорхойлолтод нийцэж, шаардлага хангаж буй иргэнийг Төрийн албаны тухай хуль, Хөдөлмөрийн хуульд дагуу тухайн албан тушаалд томилсоны дараа хөдөлмөрийн гэрээг байгуулах.

Илэрсэн асуудал 5	Жирэмсний болон амаржсны амралт, хүүхэд асрах чөлөөтэй үндсэн албан хаагчийн тушаалыг тухайн албан тушаалаас чөлөөлсөн тушаал гаргасан.
--------------------------	---

Бодит нөхцөл байдал:

Үндсэн албан хаагчийг чөлөөлсөн тушаалыг 2 албан хаагчид гаргасан.

1. 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн Б.Долгоржавыг ажлаас чөлөөлөх тухай Б/09 дүгээр тушаал,
2. 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Б.Дуламсүрэнг ажлаас чөлөөлөх тухай Б/20 дугаар тушаал,

Шалгуур үзүүлэлт:

Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3-д жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй;

Үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Хөдөлмөрийн маргаан үүсэх

Зөвлөмж:

Жирэмсний болон амаржсны амралт, хүүхэд асрах чөлөөтэй үндсэн албан хаагчид хугацаатай чөлөө олгох тушаал гаргах бөгөөд амралтаа хугацаа дуусмагц урьд эрхэлж байсан албан тушаалд эгүүлэн томилох.

Илэрсэн асуудал 6	Төвийн дарга нь албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдэд захиргааны шийдвэр гаргахдаа мэдэгдэл тайлбарыг тухай бүр гаргадаггүй.
--------------------------	---

Бодит нөхцөл байдал:

Төвийн дарга О.Ганбатын эхнэр Д.Шүрэн-Эрдэнэ Уур амьсгалын сүлжээ хариуцсан технологич инженерээр ажилладаг, төрсөн эгч О.Сувдмаа нь Ерөө ус цаг уурын өртөөний ахлах техникчээр ажилладаг, түүний нөхөр С.Төмөрбаатар нь Ерөө-Ерөө ус судлалын харуулын ажиглагчаар ажилладаг бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" заалтыг хэрэгжүүлж ажилладаггүй.

Шалгуур үзүүлэлт:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4. энэ хуулийн 10^{1.1}, 10^{1.2}, 10^{1.4}, 10^{1.5} дахь хэсэг, 11, 12, 15, 16 дугаар зүйлд заасныг зөрчсөн, энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, энэ хуулийн 29.2.3-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах.

Үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Ашиг сонирхлын зөрчил үүсэх

Зөвлөмж:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасны дагуу нийтийн албан тушаалтан нь өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээддээ захиргааны аливаа шийдвэр гаргах бүрд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын 4-р хавсралтаар баталсан мэдэлдэл, тайлбарыг заавал гаргаж, ЭБАТ-д бүртгүүлж байх.

Илэрсэн асуудал 7

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмыг баримталдаггүй, цалингийн сан хүрэлцэхгүй шалтгааны улмаас шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг дутуу олгодог.

Шалгуур үзүүлэлт

-Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах";

-Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3-т "шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно", 109.8-д Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно";

-Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 2.3. "шөнийн цагаар ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр (нэг аравны хоёроос дээш байхыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээнд тусган зохицуулж болно.) дахин нэмэгдүүлэн тооцно", 2.5. "албан хаагчийг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг олгоно. Ээлжээр ажилладаг албан хаагчийн ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдрөөр ажилласны нэмэгдэл хөлс олгохгүй".

Асуудлын үндсэн шалтгаан:

-Цалин хөлсний батлагдсан төсөв дутагдалтай байдал;

-Удирдлага, нягтлан бодогчийн ур чадвараас хамаарч төсвийн төсөөлөлд шөнийн нэмэгдлийн 1.2 дахин тооцоогүй;

-Удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллаагүйгээс;

Үзүүлэх нөлөө /үр дагавар/:

-Хариуцлагын тогтолцоо алдагдах;

Зөвлөмж:

-Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3, 109.8 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ыг хэрэгжүүлж 2026 оны төсвийн төсөөлөлд шөнийн нэмэгдлийн хувийг зөв тооцож, дээд шатнай байгууллагад хүргүүлж байх;

-Хууль, дүрэм журмын өөрчлөлтийг тухай бүр хэрэгжүүлж ажиллах;

-Удирдлага, албан хаагчийг үнэн зөв, бодитой мэдээллээр хангаж ажиллах;

ТАВ. ДҮГНЭЛТ

1. Байгууллагын засаглалын төлөвшлийн хувьд Сэлэнгэ аймгийн УЦУОШТ нь өөрийн зорилго, зорилтоо тодорхойлж, түүний хүрээнд шаардлагатай чиг үүрэг бүхий бүтэц, орон тоог баталж, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаж байна.

2. Байгууллагын даргын тушаалаар даргын дэргэдэх зөвлөлийг байгуулж, түүний ажиллах журмыг тушаалаар баталсан хэдий ч журмын дагуу үйл ажиллагаа хангалттай явуулаагүй байна. Мөн даргын тушаалаар дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх журмыг баталсан ч дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журам, стандартын дагуу тайлагнасан байна.

4. Шинжилгээний ажиглалтыг хийхдээ “Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар /ШЗ.И.01.03.2014/ буюу цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар /XIV дэвтэр/” зааврыг бүрэн баримтлаагүй байна.

5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу төвийн дарга нь албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдэд захиргааны шийдвэр гаргахдаа мэдэгдэл тайлбарыг тухай бүр гаргаагүй.

6. Жирэмсний болон амаржсны амралт, хүүхэд асрах чөлөөтэй үндсэн албан хаагчийн тушаалыг тухайн албан тушаалаас чөлөөлсөн тушаал гаргасан байна.

7. Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3-т “шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно”, 109.8-д “Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно” заалтыг хэрэгжүүлэхэд тухайн жилийн батлагдсан нийт цалин хөлсний төсөв хүрэлцдэггүй.

8. Байгууллагын засаглал, санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа зөрчлийн үр нөлөөг үндэслэн “Хэдийгээр хяналтын орчин зохистой боловч зарим хяналттай холбоотой алдаа зөрчил, асуудал илэрсэн” үед өгдөг “САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ” дүгнэлтийг өгч байна.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Аудитаар илэрсэн алдаа, дутагдлыг цаашид давтан гаргахгүй байх дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны онцлогт нийцсэн дотоод хяналтыг хэрэгжүүлэх журмыг батлах, түүнийг мөрдөж ажиллах;

2. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нийтлэг журам”-ын дагуу дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/421, А/115, А/170 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын

төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам"-ын 8-д заасны дагуу "Байгууллагын дарга, захирлаас бусад албан хаагчдын Ур чадварыг үнэлж, дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах ажилтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ", 10-д "Ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг мөрдөж ажиллах;

4. Улирлын онцлог байдал тэдгээрт харгалзах үүл үзэгдэл түүний уялдаа холбоо, ямар үзэгдэл ямар утгат хүрэхэд аюул агаар мэдээ зохиох, үүл үүсэх, хөгжих, хувьсах, сарних нөхцөл, хамт ажиглагдах үүл болон техник, шүүмж шалгалтаар илэрсэн алдааг засах сургалтыг тогтмол хийх;

5. Цаг уурын өртөө, харуулын техникч нар цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар /"ШЗ. II.12.01.2014"/-ыг баримтлах, нэн тэргүүнд цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн талаар 7-19 дугаар хуудсыг бүрэн өөрийн болгох, шат дараалсан техник шалгалтыг тогтмол хийж хэвших;

6. Дээд шатны төсвийн захирагчийн баталсан бүтэц орон тоо, төсвийн хязгаарт багтааж ажиллах, шаардлагатай гэж үзвэл төслийг бодитойгоор төлөвлөн, тулгамдаж буй асуудлыг дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;

7. Аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчлийг таслан зогсоох, үүсэж болзошгүй төсөв, санхүүгийн эрсдэлийг тодорхойлон түүнд анхаарал хандуулж, дүгнэлт хийж ажиллах;

8. Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.1-д "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэж заасны дагуу томилолтын удирдамж, төлөвлөгөө баталж байх;

9. Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.2-т "Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна" гэж заасны дагуу хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах;

10. Байгууллагын ажлын байранд суурин ажилладаг албан хаагч болон ажил үүргийн онцлог ээлжийн ажилтны цаг ашиглалт, цаг бүртгэл хөтлөлтийг хөдөлмөрийн дотоод журамд нарийвчлан оруулах, цаг ашиглалтад дотоод хяналт тавих;

11. Засгийн газрын 2018 оны 382 тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 5 дахь хэсэгт "Төрийн алба хаасан хугацааг байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж буюу ажилтан тодорхойлж, тухайн байгууллагын төсвийн шууд захирагчийн тушаалаар энэ журмын 2-т заасны дагуу нэмэгдэл олгох хувийг тогтооно" гэж заасныг мөрдөж ажиллах;

12. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг мөрдөж ажиллах, хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжуулалтад байнгын хяналт тавьж, хадгалах, хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх;

13. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/100 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам", Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллах, байгууллагын нийт ажилтнуудад албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах;

14. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг баримталж, төрийн үйлчилгээний албан хаагчдын тухайн жилийн ажлыг төлөвлөж, тайлагнуулж байх;

15. Байгууллагын дарга нь Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын 2.6-д заасан арга хэмжээнээс жилд 2-с доошгүй арга хэмжээг сонгож, төлөвлөж хэвших;

16. Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам"-ыг хэрэгжүүлэх, журмын 2.1.10-д "Монгол Улсын хууль, Засгийн газрын шийдвэрээр үйл ажиллагаа нь тодорхойлогддог, эрх олгогдсон төрийн бусад байгууллага (газар, хороо, зөвлөл, комисс, алба, төв, хүрээлэн гэх мэт)" гэж заасны дагуу байгууллагын тамгыг шинээр хийлгэх, тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалт, бүртгэл тооцооны хяналтыг сайжруулах;

17. Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулах;

18. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасан байх тул цаашид зөрчлийг арилгаж өөрийн хамаарал бүхий этгээдийг шууд удирдах, захиргааны шийдвэр гаргахгүй байх;

19. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу ашиг сонирхлын зөрчил үүссэн, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдлын тухай мэдэгдлийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбарыг нээлттэй мэдээллэх;

20. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлыг зохион байгуулахдаа хуулийн дагуу нээлттэй, ил тод, хяналт тавьж, гэрээний ерөнхий нөхцөлд гүйцэтэгчийг хууль бусаар сонгон шалгаруулсан эсхүл хууль бус давуу байдал олж авч гэрээг байгуулсан нь шүүх болон холбогдох байгууллага, албан тушаалтан тогтоосон бол гэрээг цуцлах заалтыг нарийвчлан оруулж байх;

21. Үндэсний аудитын газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитын газраас 2023 он болон 2024 оны санхүүгийн тайлан, болон тус газрын дотоод аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, төсөв, санхүүгийн эрсдэл үүсгэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг тодорхойлон түүнд анхаарал хандуулж, дүгнэлт хийж, зөрчлийг таслан зогсоохыг зөвлөж байна.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА

Э.БАТТУЛГА

2025 оны 12 дугаар сарын 07.

ТАНИЛЦСАН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС, ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА

О.ГАНБАТ

2025 оны 12 дугаар сарын ...

ХЯНАСАН:

ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ОЮУНБИЛЭГ

2025 оны 12 дугаар сарын 11

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

С.НАРАНЧИМЭГ

2025 оны 12 дугаар сарын 10

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЦЭЦЭГЖАРГАЛ

2025 оны 12 дугаар сарын ...